

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ МЭДЭЭ **(2012 оны 17, 18 дахь долоо хоног)**

АНУ

АНУ-ад 2012 оны 3 дугаар сард хүлээж байснаас их буюу жилийн 328,000 байр шинээр зарагдсаныг судлаачид ажлын байр нэмэгдэж байгаагаас гадна орон сууцны зээлийн хүү бага түвшинд хэвээр байгаатай холбон тайлбарлаж байна. 2012 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр АНУ-ын Худалдааны яамнаас гаргасан мэдээнээс харахад, 2012 оны 2 дугаар сард орон сууцны борлуулалт сүүлийн хоёр жилийн турш байгаагүй өндөр түвшин буюу 353,000-тай тэнцэж байснаа эргэн бага зэрэг буурчээ. Ажил олголт их, орон сууцны зээлийн хүү түүхэнд байгаагүй доод түвшинд, орон сууцны үнэ хямд хэвээр байгаа зэрэг нь АНУ-ын эдийн засгийн хамгийн хүндрэлтэй салбар болох орон сууцны зах зээлд эерэгээр нөлөөлж байгаа ч борлогдохгүй удсан үл хөдлөх хөрөнгүүд орон сууцны үнэд “дарамт” болсоор байна гэж судлаачид дүгнэжээ.

2011 оны IV улиралд жилийн 3 хувиар тэлээд байсан АНУ-ын эдийн засаг 2012 оны эхний улиралд жилийн дөнгөж 2.2 хувиар тэлсэн тухай мэдээллийг тус улсын Худалдааны яамнаас 2012 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр өглөө. Эдийн засгийн судлаачид энэхүү өсөлтийг ажил олголт нэмэгдэж, иргэдийн орлого нэмэгдэхийн хэрээр тэдний мөнгө зарцуулалт даган өссөн үзэгдлээр тайлбарлаж байгаа билээ. Үнэндээ тайлант хугацаанд хэрэглэгчдийн худалдан авалт өмнөх улирлаас 2.9 хувиар нэмэгджээ. Эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлсөн бусад салбар гэвэл орон сууцны барилга болон автомашины үйлдвэрлэлийг нэрлэж болно. Ялангуяа барилгын салбарт сүүлийн жилүүдэд төдийлөн сайшаалтай үзүүлэлт ажиглагдахгүй байсан тул энэ маш таатай мэдээ билээ. АНУ-ын ДНБ-ийн өсөлтийг хурдыг сааруулсан салбараар тоног төхөөрөмжинд оруулсан хөрөнгө оруулалтын салбар хэмээн дээрх мэдээнд нэрлэжээ.

Евро-бүс

Евро-бүсийн үйлдвэрлэл, үйлчилгээний салбар 2012 оны 4 дүгээр сард хумигдсан нь бүс нутгийн эдийн засаг сайжраагүй байгаагийн илрэл гэж судлаачид дүгнэж байна. Лондон хотноо байршилтай Markit Economics судалгааны байгууллагаас гаргасан судалгаагаар Евро-бүсийн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын purchasing managers index 2012 оны 3 дугаар сард 49.1 нэгж байснаас буурч 47.4 нэгжид хүрчээ. Энэ үзүүлэлт 50 нэгжээс бага гарвал тухайн салбар хумигдсаны илрэл болдог билээ. Евро-бүсийн орнуудын удирдлагууд өрийн хямралтай тэмцсэн хэвээр байгаа энэ үед төсвийн таналт явагдаж байгаагийн хажуугаар ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр байгаа нь эдийн засагт сайнаар нөлөөлөхгүй байна. “2011 оны сүүлийн улиралд өмнөх улирлаас 0.3 хувиар удаашраад байсан Евро-бүсийн эдийн засгийн өсөлт 2012 оны эхний улиралд нэмж удааширнаар барахгүй 2012 оны 4 дүгээр сарын зах зээлийн судалгаанаас харахад бүс нутгийн эдийн засаг 2012 оны II улиралд ч мөн хумигдагдах төлөвтэй” гэсэн таамгыг HIS Global Insight байгууллагын эдийн засагч Howard Archer дэвшүүлээ.

Хэрэглэгчид эдийн засгийн цаашдын чиг хандлагыг хэр зэрэг эерэгээр харж буйг илтгэдэг хэрэглэгчдийн итгэлийн индекс Евро-бүсэд 2012 оны 4 дүгээр сард хүлээж байснаас ихээр буурчээ. Европын комиссоос 2012 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр мэдээлснээр 2012 оны 3

дугаар сард 94.5 нэгжтэй тэнцэж байсан Евро-бүсийн хэрэглэгчдийн итгэлийн индекс буурч 2012 оны 4 дүгээр сард 92.8 нэгжид хүрсэн байна. Блумберг агентлагаас нийт 29 судлаачдын дунд явуулсан судалгаанаас харахад, тэд энэхүү үзүүлэлтийг дөнгөж 0.2-0.3 нэгжээр л унана гэсэн хүлээлттэй байсан нь ийнхүү том эндүүрэл болжээ. Үнэхээр Европ тив даяар явагдаж буй төсвөө танах бодлого ажил олголт, улмаар хэрэглэгчдийн итгэлийн түвшинд энэ мэт сөргөөр нөлөөлсөөр байгаа. ING Group дэх судлаач Martin van Vliet-ийн үзэж байгаагаар, төсвийн зардлыг цаашид ч бууруулах төлөвтэй байгаа энэ онд эдийн засгийн эерэг чиг хандлага ажиглагдахгүй нь. Европын комиссын тайлангаас харахад, Итали улсад бизнес эрхлэгчдийн итгэлийн түвшин гэхэд 2009 оны 10 дугаар сараас хойш байгаагүй доод түвшинд хүрчээ. Тус улсын Ерөнхий сайд Mario Monti-гоор ахлуулсан Засгийн газрын тооцоолсноор Итали улсын эдийн засаг 2012 онд жилийн 1.2 хувиар хумигдах нь. Тэд үүнтэй холбогдуулан Итали улсын төсвийн алдагдлыг 20 тэрбум еврогоор бууруулах “хатуу” төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхлээд байгаа билээ.

Евро-бүсийн инфляцийн түвшин 2012 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурч жилийн 2.6 хувьд хүрчээ гэсэн урьдчилсан тооцооллыг Европын холбооны Статистикийн албанаас 2012 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр гаргалаа. Европын Төв банкны Ерөнхийлөгч Mario Draghi ч 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хийсэн мэдэгдэлдээ инфляцийн эрсдэл “харьцангуй тогтворжсон” гэж үзэж буйгаа илэрхийлсэн нь ийнхүү батлагдаж байна. Газрын тосны үнэ бага зэрэг буурснаас гадна бүс нутгийн эдийн засгийн өсөлт удааширсан зэргээр инфляцийн түвшний бууралт тайлбарлагдаж байгаа тул Европын Төв банкны бодлогын хүүг ойрын хугацаанд нэмэгдэхгүй гэсэн таамгыг тухайлбал ING Group-ын эдийн засагч Peter Vanden Houte дэвшүүлжээ. Европын Төв банкны Мөнгөний бодлогын зөвлөл 2012 оны 5 дугаар сарын 03-ны өдөр хуралдан бодлогын хүүгээ жилийн 1 хувьд хэвээр үлдээсэн билээ.

Евро-бүсийн ажилгүйдлийн түвшин 2012 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.1 нэгж хувиар нэмэгдэн 10.9 хувьд хүрсэн тухай Европын холбооны Статистикийн албанаас 2012 оны 5 дугаар сарын 02-ны өдөр мэдээллээ. Энэ нь Блумберг агентлагт хуримтлагдсан мэдээллээс харахад 1997 оны 4 дүгээр сараас хойш байгаагүй өндөр түвшин болжээ. Өрийн хямралаас гарахын тулд төсвийн “хатуу” бодлого явуулж буй энэ үед хөдөлмөр эрхлэлтийн талаарх энэхүү таагүй мэдээлэл нь Европын улс төрчдөд нэмэлт “дарамт” болж байна. Бүс нутгийн орнуудаас Испани улсын ажилгүйдлийн түвшин 24.1 хувиар хамгийн өндөр нь байгаа бол Австри болон Нидерланд улсын ажилгүйдлийн түвшин тус тус 4 болон 5 хувьтай тэнцсэнээр хамгийн багад тооцогджээ.

Их Британи

Их Британий хэрэглэгчдийн итгэлийн индекс 2012 оны 3 дугаар сард 53 нэгж хүртэл өсчээ. Энэхүү үзүүлэлт 2012 оны 02 дугаар сард дөнгөж 44 нэгжтэй тэнцэж байсан тухай Nationwide Building Society байгууллагаас 2012 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр мэдээлсэн. Гэвч судлаачид хэрэглэгчдийн өөдрөг үзэл цаашид эргэн буурна гэсэн таамгыг дэвшүүлж байгаа. Учир нь 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Их Британи улсын эдийн засаг 2012 оны эхний улиралд жилийн 0.2 хувиар хумигдсан тухай мэдээлэл цацагдсан билээ. Эрчим хүчний түүхий эдийн үнийн өсөлт, Их Британи улсын төсвийн таналт зэргээс гадна тус улсын иргэдийн цалингийн өсөлт удааширсан зэрэг явдал хэрэглэгчдийн мөнгө зарцуулалтыг сааруулж байна.

Их Британий барилгын салбарын талаар хэд хэдэн мэдээлэл 2012 оны 5 дугаар сарын 2-ны өдөр гарчээ. Тухайлбал, Их Британид олгогдсон орон сууцны зээлийн хэмжээ 2012 оны 2 дугаар сард 49,029 байснаас өсч 3 дугаар сард 49,860-г хүрсэн тухай Английн Төв банкнаас мэдээлсэн бол тус улсад шинээр баригдсан барилгын тоо 2012 оны 4 дүгээр сард өмнөх сараас буурсан тухай Markit Economics болон Chartered Institute of Purchasing and Supply зэрэг байгууллагуудын хамтран гаргасан мэдээнд дурьджээ. Барилгын салбарын идэвхижлийг харуулдаг индекс 2012 оны 2 дугаар сард 56.7 нэгж байснаас буурч 3 дугаар сард 55.8 нэгжид хүрсэн байна.

Валютын ханш

	12.04.30	12.05.01	12.05.02	12.05.03	12.05.04	Өөрчлөлт
EUR/USD	1.3239	1.3237	1.3158	1.3152	1.3084	-1.17%
GBP/USD	1.6234	1.6221	1.62	1.6178	1.6151	-0.51%
USD/CHF	0.9075	0.9078	0.9131	0.9135	0.9182	1.18%
USD/JPY	79.82	80.09	80.14	80.18	79.85	0.04%

Металлын ханш

	12.04.27	12.04.30	12.05.01	12.05.02	12.05.04	Өөрчлөлт
Алт (\$/унци)	1664.75	1662.43	1653.5	1635.98	1642.22	-1.35%
Зэс (\$/тонн)	8564	8534.5	8537	8399	8284.5	-3.26%

Эх сурвалж: Bloomberg, Reuters, Financial Times

Жич: Энэхүү нийтлэл нь зөвхөн мэдээллийн шинж чанартай бөгөөд үүн дээр үндэслэн хийгдсэн аливаа шийдвэрийг Монголбанк хариуцахгүй болно.